



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/415

Булган сум

**Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй болон бусад худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хязгаарыг тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.2, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 23 дугаар зүйлийн 23.1, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээний согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), сумын Засаг дарга нарт, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан)-д даалгасугай.


3. Энэхүү захирамжийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараа дагаж мөрдсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

06 дугаар сарын 05-ны/ний өдрийн 05/А/10 дугаар захирамжийн хавсралт



**Булган аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй болон бусад худалдаа үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаар**

Д/д	Худалдаа үйлчилгээний төрөл	Тусгай зөвшөөрлийн ангилал	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаар	
			3	4
1	2	3	4	
1	Хүнсний бөөний худалдаа	Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй	07.00	22.00
2	Хүнсний жижиглэн худалдаа	Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй	07.00	24.00
3	Ая тухтай дэлгүүр	Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй	07.00	24.00
4	Жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын дэргэдэх ресторан, баар, кафе	11.00-22.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	11.00	22.00
5	Жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын дэргэдэх ресторан, баар, кафе	14.00-04.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	14.00	04.00
6	Ресторан, кафе	11.00-22.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	11.00	22.00
7		14.00-04.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	14.00	04.00
8	Баар	11.00-22.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	11.00	22.00
9		14.00-04.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	14.00	04.00
10	Улирлын чанартай түр сүүдрэвчтэй үйлчилгээ	11.00-24.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	08.00	24.00
11	Хүнсний зах, худалдааны төв	Хүнс, өргөн хэрэглээний бараа, барааны зах	07.00	24.00
12	Хүнсний жижиглэн худалдаа, мухлаг		07.00	24.00
13	Хүнсний бус барааны худалдаа		07.00	24.00